

ДАРЬГАНГЫН БҮГДИЙН ТЭРГҮҮН НАРЫН ЗӨРЧИЛ

Т.Билэгсайхан

Товч утга: Энэхүү өгүүлэлд 1911 онд Дарьгангыг Монгол улсад нэгдсэн үеэс 1925 онд Дарьганга хошуу болох хүртэлх тухайн бүлгийн түүхэн үйл явцыг удирдлагуудын зөрчлүүдээр төлөөлүүлэн тодруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Содномдовдон, Буяндэлгэр, Цэвэгжав, Цэрэнпалам, Цэрэнтогтох, Магсаржав

Удиртгал

Манж Чин Улсын эзэн хааны сүргийг адгуулах сүрэгчин захиргаа байгуулагдаж түүнийг бүгдийн тэргүүн захирч байв. Албан бичигт Дээдийн адууны Дарьганга дахь морь тэмээн сүргийг захирагч бүгдийн тэргүүн. Ийнхүү Дээдийн адуу хэмээх нь Манжийн хааны сүргийг нэрлэж ойлгож иржээ. Манж Чин Улсын үед Дарьгангын тэргүүнийг сонгох журмаар тавихдаа зөвхөн гарын дарга нарын дотроос эрдэм чадалтай, олныг удирдаж чадахыг нь харгалзан тохоогоод Чуулгат Хаалганд суух Цахар найман хошууг захирагч сайдад уламжлан өргөж баталгаажуулдаг байв.

XVIII зууны сүүл үеэс эхлэн тогтвортой ажиллаж байсан бүгдийн тэргүүн нарыг тодруулбал:

1. Түгжжав
2. Цэнгүнжав
3. Вандандорж
4. Баатар
5. Жамъянжав
6. Донров
7. Сүндэв
8. Буяндэлгэр
9. Содномдовдон
10. Цэвэгжав
11. Магсаржав
12. Цэрэнтогтох
13. Цэрэнпалам

Хэдийгээр Дарьгангын удирдлага нь угсаа залгамжилдаггүй гүйдэг тушаалын боловч бүгдийн тэргүүнийг тохоохдоо гарын дарга нарын дотроос сонгодог, гарын дарга нарыг тохоохдоо ард олныг баримтлан захирах, эрдэм

чадлыг харгалздаг ч бүгдийн тэргүүний оролцоо байв. Энэхүү тогтолцоо нь нийгмийн удирдлагад бүлэг хүмүүс бүрэлдэх шалтгаан болжээ. XX зууны эхэн үе гэхэд Дарьгангын удирдлагад хоёр бүлэг нэгэнт бий болсон байна.

Нэгдүгээрт: Бүгдийн тэргүүн Буяндэлгэр, "... түүний ач Өлзий зүүн гар адуучны гарын дарга, ураг элгэн Дугарсүрэн баруун гар адуучны гарын дарга, хүргэн Өлзий зүүн гарын тэмээн сүргийн дэд гарын даргаар ажиллаж"¹ байв.

Хоёрдугаарт: Бүгдийн тэргүүн Содномдовдон (Тэрбээр Дотоод яамнаа өргөсөн бичигт: "... Миний өндөр өвгөөс эхлэн үе улиран бүгдийн тэргүүн, гарын тэргүүн зэргийн захирах тушаалд тасралтгүй дэвшсээр ирсэн удаа бүр өргөмжлөл олсон сурвалжит гарын хүн өчүүхэн миний үед хүрч Богд эзэн гэгээн хааны гүн их хүнд хишигт улсын түшээ гүнгийн хэргэм шагнагдсан билээ"² хэмээсэн байдаг), түүний хөвгүүн Цэвэгжав бүгдийн тэргүүн, ач Цэрэнпалам зүүн гарын тэмээн сүргийн гарын тэргүүн нарын зэрэг түшмэд болно. Энэхүү 2 бүлэг Дарьгангын хошуу байгуулагдах хүртэл удирдлагад ажиллаж иржээ. Эдний дээр хонин сүргийн гарын дарга Магсаржав, 1913 оны таван замын цэрэгт идэвхтэй оролцож Дарьгангын цэргийн хорооны дарга болсон Цэрэнтогтох нарын түшмэд багтаж орсон байна.

1. Содномдовдон & Буяндэлгэр

1911 онд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хувьсгалын цар хүрээ нийт монгол туургатныг хамрах болов. Энэ нь Дарьгангын түшмэдүүдийн анхаарлыг зүй ёсоор татсан байна. Иймд бүгдийн тэргүүн Содномдовдон өөрийн хөвгүүн "... Цэвэгжавыг нууцаар илгээж тулгар төр байгуулах хэргийг дэмжиж буйгаа илэрхийлжээ"³.

Иймээс 1911 оны 12 сарын 29-ний өдөр Богд Жибзундамба хутагт Шашин, төрийг хослуулан барьсан хаан ширээнд өргөмжлөгдөөд мөн өдөр зарлигаар тусгаар тогтнолоо сэргээхэд хүчин зүтгэсэн нийт хүмүүсийг сайшаан хөхийүлсэний дотор "... Дарьгангаас хамгаас түрүүнд дагаар орсон бүгдийн тэргүүн Содномдовдонд үе улиран засаг, улсын түшээ гүн, мөн хөвгүүн Цэвэгжавт дэд зэрэг жинс, торгон дэвсгэр, Цэвэгжавыг дагалдан ирсэн Тогтоход дөтгөөр зэрэг жинс шагнав"⁴ хэмээжээ.

Үүний дараагаар Дотоод яамнаас Олноо өргөгдсөний тэргүүн он өвлийн дундад сард (1911.12.20-1912.01.19) Дарьгангын бүгдийн тэргүүн засаг, улсын түшээ гүн Содномдовдонд бичиг явуулсан байна. Үүнд, "... Содномдовдон үнэнхүү сүслэн биширсний тулд хишиг хүртээн түүнд үе улиран залгамжлах засаг улсын түшээ гүн шагнаж засгийн тамга олгуулан харъяат сүрэгчин хошуу сум зохион захируулж Сэцэн хан аймагт хавсруултугай. Гарын дарга нарт өөр өөрийн гавъяаг үзэж тус бүр хэтэрхий хишиг шагнахыг хүлээгтүн. Үүнийг засаг улсын түшээ гүн Дарьгангын бүгдийн тэргүүн Содномдовдонд мэдтүгэй хэмээн явуулаад өршөөлт хишиг Зарлигийг хичээнгүйлэн дагаж

¹ МУУТА, ХА-3. Д-1. ХН-13. Х-368-417

² МУУТА, ХА-3. Д-1. ХН-14. Х-234-238 а

³ МУУТА, ХА-3. Д-1. ХН-13. Х-368-417

⁴ МУУТА, ХА-6. Д-1. ХН-511. Б-4

явуулахаас гадна зөвлөн тогтоолцож тодорхойлох хэмээсэн хэргийг бүрнээ хурданаар гүйцэлдүүлэн басхүү нэгэнтэйгүүр харъяат түшмэл ардын хүн амын тоог уул адгуулан бүхий сүрэг малын дансыг тус бүр тодорхойлон хариу ирүүлээд уламжлан айлтгахад бэлтгүүлбээс зохимуй”⁵ хэмээн тушаасан ажээ.

Ийнхүү Монгол Улсын Засгийн газраас Манжийн эзэн хааны сүргийг адгуулах албатай, сонгох тушаалын бүгдийн тэргүүнтэй Дарьгангын бусад хошууд лугаа адилтган засаг өргөмжлүүлж, ойр залгаа аймагт хавсаргасан нь тус нутагт гарын тэргүүн нарын эсэргүүцэх, заргалдах байдалд хүргэсэн байна. Энэ бол шинэ тулгар тогтсон Засгийн газар Дарьгангын байдлыг нарийвчлан харгалзаагүйн улмаас үүдсэн бололтой. Сул Буяндэлгэр тэргүүлэн, гарын дарга нар нэр хамтарч,

“... хойч өдөр түүнд захирагдаж хэрхэвч чадахгүй тул эл учрыг эртнээс мэдүүлж дагаж явах шулуун зам олгомуй хэмээн олноор цурхалдан хэлэхэд өчүүхэн гарын дарга нар хөндөлдөн саатуулахгүй олохгүй олны төлөө харилцан мэдүүлэх ба дээрийн биеэр айлтгахыг хүсэж өргөв”⁶

хэмээн заалдан тэмцжээ. Үүнд гарын дарга Цэрэнпалам тэргүүлэн Дарьгангын нөлөө бүхий дэд гарын дарга, бичээч, сүмийн хамба лам нарын зэрэг 24 хүний хамт Содномдовдонг хамгаалан өргөх бичиг өргөсөн байна. Үүнд,

“... зальхай сул Буяндэлгэрийн зэрэг өөдлөшгүй ард шударга төвшин хүн нарын яахин хутган сэтгэлийг хөдөлгөн мунхруулж хөхиүлэхэд хүргүүлснийг үгүй болгох газаргүй. Одоо бидний доорд боолчууд элдэвлэвч энэ ба хойчийг илтгэн тусгайлан айлтгах Богд эзэн гэгээн хааны дээд зарлигаар зааж байгуулсан харъяат засаг улсын түшээ гүн ноён танаа захируулахыг хэрхэвч үнэн туйлаас хөдөлбөргүй батлаж хүсмүй”⁷

гэх зэргээр мэдүүлцгээж байв.

Эдгээр зарга мэдүүлгийг Дотоод яамнаас уламжлан айлтгасанд Содномдовдон анх дагаар ирсэн нь нэн өршөөлтэйн дээр цагийн байдлыг харгалзан Цахар сайдад холбоотой явсан нь хоёр санаа гаргасан биш харин ч харъяат ардыг зовлонд учруулахаас сэргийлсэн зөв бодлого явуулсан хэмээн сайшаан Буяндэлгэр бүгдийн тэргүүний оронд тохуулахыг гуйн мэдүүлснийг,

“... Буяндэлгэр болбоос урьд бүгдийн тэргүүний тушаал бүхийд харъяат сайдаас буруушаан айлтгаж тушаалаас

⁵ МУУТА, ХА-3. Д-1. ХН-292. Б-1

⁶ МУУТА, ХА-3. Д-1. ХН-13. Х-368-417

⁷ МУУТА, ХА-3. Д-1. ХН-13. Х-368-417

огцруулсан нь түүний ямар сайн явсан гавъяа буй учир болой одоо аваас манай тулгар төрд чингэж зүй бусаар зарга тэмцэл өдүүлэн явсан нь тийнхүү чухал тушаалд улиран хэрэглэх байтугай урьд хэрэгт ял хэлэлцэхийг өршөөн хэлтрүүлснийг нь уг айлтгаад шийтгэсэн хэргийн дотор тодорхой атал одоо дэвшихийг эрхэмлэн мэдүүлэх нь үнэхээр мунхаг балмадын туйлд хүрснээ өөрөө гэрчлэн гаргажээ, дэвшихийг эрж мэдүүлсэн тэрслүү мунхаг Буяндэлгэрийг албаны тушаалд хэрэглэхийг огт хэрэгсэхгүй”⁸

хэмээн тушаажээ. Гэвч Дарьгангын түшмэдийн зөрчил гүнзгийрч хилийн газар алба хийдэхэд тулгарсан учир засаг болгон Сэцэн ханы харъяанд хавсаргаснаа зогсоож олон жилийн турш мөрдөгдөж ирсэн бүгдийн тэргүүнийг сонгодгийг хэвээр болгон, Дотоод яаманд шууд харъяалагдах болов. Улмаар Монгол Улсын Засгийн газраас Дарьгангын сүрэг адгуулах тусгай захиргаа онцлогийг харгалзан,

“... харъяат бүх түшмэл сүрэг захиран адгуулсан түшмэл хуягуудын жил тутам хүртээвээс зохих пүнлүү цалингийн тоо, үржүүлэн адгуулсан таван гарын гурван зүйл сүрэг малыг хуучин хэвээр үржүүлэн адгуулж жил тутам үржүүлэх татан авах унагаж тайлах язгуурын эх тоог эрхлэн нөхөж дүүргэсээр байх Дотоод яамнаас гурван жилд нэгэн удаа түшмэлийг гаргаж байцаалгах зэргийг цөм хуучин ёсоор дүрэм болгон тогтоосон”⁹

байна. Ийнхүү Дарьгангын бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт хийхээ зогсоож хэвээр хадгалахад хүрснээр хэсэг хугацаанд зөрчил намжсан ажээ.

2.Цэвэгжав & Цэрэнпалам

1914 оны хавар бүгдийн тэргүүн Содномдовдон Нийслэл Хүрээнээ бие өвчтэй улмаас эмчлүүлж байсан учир гарын тэргүүн Цэрэнпалам бүгдийн тэргүүний тушаалыг хамаарч байв. Удалгүй орон гарсан бүгдийн тэргүүнд тохоох түшмэдийг сонгон томилж ирүүлсүгэй хэмээн Дотоод яамнаас хамаарсан бүгдийн тэргүүн Цэрэнпаламд тушаажээ. Үүнд тэрбээр:

“... гарын тэргүүн Өлзий, Дугарсүрэн нарын бие өвчтэй, гарын дарга Магсаржав Бүгд Ерөнхийлөн Захирах Яамны дэс түшмэлийн алба хааж бүхий учрыг гаргаж эдүгээ алба төлөөлж буй дарга Цэрэнпалам, Түгж нарын нэр зэргийг мэдүүлэн ирсэнд”¹⁰

⁸ МУУТА, ХА-3, Д-1, ХН-14, Х-192-19

⁹ МУУТА, ХА-3, Д-1, ХН-151, Б-8

¹⁰ МУУТА, ХА-3, Д-1, ХН-92, Х-76-9

Дотоод яамнаас өөрийн биеийг илтэд гаргав хэмээн хатуугаар буруушаан таван гарын дарга нарын биеийг бүрэн мэдүүлэн дахин ирүүл алгуурлан одуулахгүй болгосугай хэмээн тушаасан байна. Иймээс 1914.11.02-нд,

“... Дарьгангын хамаарсан бүгдийн тэргүүн, зүүн гар тэмээн сүргийн гарын дарга Цэрэнпалам, дэс түшмэл, улсад туслагч гүн, хонин сүргийн гарын дарга Магсаржав, баруун гар адуун сүргийн гарын дарга бэйсийн зэрэг Дугарсүрэн, зүүн гар адуун сүргийн гарын дарга Өлзий, баруун гар тэмээн сүргийн гарын дарга Түгж нарын хэнд бүгдийн тэргүүний тушаал тохоовоос зохих явдлыг айлтгасанд, зарлиг бүгдийн тэргүүнд Цэвэгжавыг тохоон талбигтун”¹¹

хэмээжээ. Ийнхүү зарлиг гарч бүгдийн тэргүүнийг сонгох журмыг эвдэн зарлигаар бүгдийн тэргүүн Содномдовдон агсны хөвгүүн жүн Цэвэгжавыг тохоосон нь гарын дарга нарын дунд дүргүйцэл гарахад хүргэж, нөгөөтэйгүүр ДИУ-ын явуулгаар Чуулалт Хаалганд суух сайдаас өөртөө татах бодлого идэвхтэй явуулж байсантай нийлэлдэн нөлөө бүхий түшмэд урагш дүрвэх болсон байна. Хамаарсан бүгдийн тэргүүн, гарын дарга Цэрэнпалам, сул Буяндэлгэр нарын зэрэг түшмэд нутгаас дүрвэн гарч Чуулалт Хаалганы сайдын газар очиж тусгай захиргаа байгуулсан байна¹².

Хиагтын хэлэлцээр байгуулагдсаны дараа 1915.07.07-нд, Буяндэлгэр, Цэрэнпалам нар Дарьгангад буцаж ирээд,

“... Цэвэгжав чиний бие өрх амын цэс олон зүйлийн сүрэг малын тоог тодорхойлон байцааж Чуулалт Хаалганаа хурдан даруй хүрч ирж нүүр учирсугай хэмээн удаа дараа чангалан тушаасан”¹³

байна. Шахаанд орсон Цэвэгжаваас хэрхэх учрыг олж мэдэхгүй хязгаар салбадаж үнэхээр айн эмээж бүхий учраа гарган ДИУ-аас түшмэл зарж ухуулсныг дагаж алба зүйлийг хүргэхээр тогтолцон буй ба аймшигтай этгээдийн аясыг дагалдан явах хэмээх зэргээр удаа дараа өргөн Дотоод яаманд мэдүүлсэнд тус яамнаас,

“... Дарьгангын нутаг болбоос угаас Халхын нутгийн дотор болох нь Харчин өртөөний нутгаас харин ч ялгаварлах газаргүй тул дараа хэдэн этгээдээр нийлэн хил хязгаарыг тогтоохын наана гэрээ бичгийг зөрчиж яахин болох аж. Учир иймийн тул харъяат бүгдийн тэргүүн ван, гарын дарга

¹¹ МУУТА, ХА-2, Д-1, ХН-209, Б-15

¹² МУУТА, ХА-2, Д-1, ХН-196, Б-4

¹³ МУУТА, ХА-2, Д-1, ХН-303, Б-10

нар тэдний хэдэн түшмэдийн элдвээр үймүүлэхийг дагалдан санаа сэтгэлийг хуваагдуулах ба олон ардын сэтгэлийг алдагдуулахгүй гэрээ бичиг ба ухуулан тушаасан бичгийг журамлан дагаж олныг зүй зохисоор тохинуулан нам гүм төвийг сахиж суусугай хэмээн тушаасан”¹⁴

байна. Гэвч хүчинд автсан Цэвэгжав эхлэн таван гарын түшмэд: “... адуу, тэмээ дөрвөн газраас хоёр зуун агт морийг сонгон авч 1915.07.15 ны өдөр Сүүж хэмээх газар нэгэн зэргээр хуралдан очиж өмнө зүгийн албыг залгамжлуулахаар”¹⁵ болжээ. Чуулалт Хаалганд захирагдахаар очсон түшмэд ардуудыг хуучин хэвээр дөрвөн гарын дарга нараар, хонин сүргийг Иш хэмээх Буяндэлгэрээр захируулж бүгдийн тэргүүн хуучин амбан Буяндэлгэрийг тохоож, Цэвэгжавыг сул ван болгосон байна.

200 гаруй жил сүрэг адгуулж тусгай нутагт суурьшиж байсан дарьгангачууд урагш Чуулалт Хаалганы зүг, хойш Сэцэн хан, Нийслэл Хүрээ зэрэг газарт дүрвэн гарах болж ихээхэн хэцүү замыг туулах болжээ.

3.Магсаржав & Цэрэнтогтох

1916 оны эхээр Халхын хошуунд нүүн ирсэн Дарьгангачуудыг засаг захиргааны зохион байгуулалтанд оруулах үед тэдний дунд маргаан үүсчээ. Хонин сүргийн аругсан гарын дарга гүн Чагдарсүрэн, зүүн гарын тэмээн сүргийн аругсан гарын дарга Насанцогт нараас эл дагаж ирсэн айл өрх цөм сайд бэйс Магсаржаваар захируулахыг хүсмүй хэмээсэнд сүргийн дарга Ядамсүрэнгийн зэрэг хүмүүсээс,

“... урвасан этгээдийн эрх дагасангүй захирлага тэмдэгийг авч Нийслэл Хүрээнээ хүрч ирснээс нааш нэвтрэн ирэх замын үүд нэгэнт шашин хэлхээ үндэс язгуурыг дагалдуулсан хамаарсан гарын дарга Цэрэнтогтохыг дагалдан түшиж захируулахыг гуйн өргөсөн”¹⁶

байна. Үүнийг Дотоод яам үзээд “... Магсаржаваар түр ерөнхийлөн захируулж, Цэрэнтогтохийг хуучин хэвээр баруун гар адуун сүргийн гарын даргаар ажиллуулсан байна”¹⁷. Энэ мэтээс үүдэн Халхын нутагт ойн гарсан Дарьгангачуудын дунд үл мэдэг зөрөлдөөнтэй байсан бололтой. Мөн үед хил залгаа нутагт идээшин суусан ардуудыг нүүлгэн нэгэн нутагт тусгай захиргаа байгуулах гэсэн оролдлого нь ардуудыг хүндрүүлсний улмаас Магсаржавыг ерөнхийлөн захирахыг 1916.08.15-нд байлгаж Цэрэнтогтохоор захируулсан байна. Үүнд Магсаржаваас дүргүйцэн,

¹⁴ МУУТА, ХА-2. Д-1. ХН-303. Б-10

¹⁵ МУУТА, ХА-2. Д-1. ХН-303. Б-16

¹⁶ МУУТА, ХА-6. Д-1. ХН-964. Х-1

¹⁷ МУУТА, ХА-3. Д-1. ХН-152. Х-38-38а

“... Цэрэнтогтохыг хулгай ховдог залхай захирах тушаалд дэвших дэвгүй хоосон зэрэгтэй хуягт захирагдахгүй хэмээгээд одоо нэгэнт захирах хүнгүй нь даруй Цахарын уул харъяат түшмэл мөний тулд Дарьгангын хошуудын адил хил хязгаар ялгахыг хүлээлгэхгүй болгон язгуур үндсийг дагуулж манай нэгэн захиргааны Жигмэдсэрэн нарын зэрэг Цахар тайбусын 17 хүн онц түшмэл миний элгэн садан ба дагагсадын зэрэг 30 өрхийн 110 хүн бүхий эл учраан өргөн мэдүүлсэн”¹⁸

хэмээсэнд Дотоод яамнаас: “... бэйс Магсаржав хэдий Цахар хошууны түшмэл Цахарын харъяат ардыг авч бусад олон дагаар ирэгсэдэд нутаг үндэс олгуулж тохинуулсны нэгэн адил болгохыг гуйсан боловч тэр угаас Дарьганга лугаа харилцан дэвших улирах дүрмийг дагаж Дарьгангын хонин сүрэг нэгэн хошууг захирсан түшмэл. Мөн харъяат сүргийн дагаар ирсэн хэргийг хараахан тогтоогоогүйд түүнийг Цахар хэмээн Дарьгангад хамаагүй болгох газаргүй бөгөөд тэдний ухуулах, агуулах, тохинуулах хэргийг Дундад, Монголын хил хязгаар хуваахын наана хэрхэвчээр тогтоож үл болох учир ухуулан тушаасан хэргийг мөн зөрчиж Цахарыг дагуулж тохиномуй хэмээн Дарьгангад хамаагүй болохоор өргөсөн хэрнээ Дарьгангын хэрэгт хэвээр оролцож хоёрдон мэдүүлснийг ихэд бураашаажээ”¹⁹.

Ийнхүү Халхын нутагт ойн гарсан ардуудыг Цэрэнтогтох ерөнхийлөн захирч байгаад 1918.10.15-нд,

“... дээд Засгийн газраас манай Дарьгангын нутгийн олныг үндэс нутгийн харьяагаар дахин эгүүлэн авч тохинуулах боловч бид бүхэн анх цагаас санаа явдлыг салж нэгэнт тусгаарласан нь болох тул хэрхэвч Дарьгангаас Иргэн улсыг дагаар орогсодыг хэрхэн тохинуулах атугай тэр цагт буцаж тэдэн лугаа нийлэлцэхийг ер хүсэх газаргүйд дагаар ирсэн 154 өрхийн 844 хүмүүс цөм шавь болохыг хүсмүй”²⁰

хэмээн өргөсөнд ёсоор болгон түүнд Их шавь Дарьгангын бүгдийн даргын тамга олгосон байна. Үүний дараа Цэрэнтогтох Их шавийн захиргаанд орохдоо сул орхисон Магсаржав нараас Дотоод яамнаа өргөсөн бичигт “... бэйсийн зэрэг гүн Магсаржав, гүнгийн зэрэг аругсан гарын дарга Чагдарсүрэн, дэд аругсан гарын дарга Мангал, да лам Балжир нарын зэрэг түшмэд Их шавьд тусгай отог болгон захируулахыг хүсмүй хэмээсэнд 1919.02.26 нд зарлигаар зөвшөөрч Магсаржаваар отог”²¹ийг захируулжээ. Ийнхүү нутгаасаа ойн гарсан ардууд дахин хуваагдан тусгай шавь болон салсан байна.

¹⁸ МУУТА, ХА-7. Д-1. ХН-329. Б-2

¹⁹ МУУТА, ХА-7. Д-1. ХН-329. Б-2

²⁰ МУУТА, ХА-3. Д-1. ХН-209. Х-123-129а

²¹ МУУТА, ХА-3. Д-1. ХН-226. Х-68-76

4. Буяндэлгэр & Цэрэнтогтох & Цэрэнпалам

Энэхүү зөрчил нь дээрхээс ялгаатай нь тусгай хоёр захиргаатай бүгдийн тэргүүний хооронд өрнөснөөрөө онцлог юм. Чуулалт Хаалганд очиж бүгдийн даргын тамга тэндээс авсан Буяндэлгэр, зүүн гарын тэмээн сүргийн гарын дарга, дэд бүгдийн дарга Цэрэнпалам, аругсан гарын дарга Өлзий, баруун гарын тэмээн сүргийн гарын дарга Түгж, аругсан гарын дарга Дамдинсүрэн нэр хамтран удаа дараа Халхын ноёдод бичиг илгээж Халхын нутагт захиргаа байгуулсан Цэрэнтогтох лугаа харъяат ардыг харилцан нэхэмжилэн зарга тэмцэл өдөөх болжээ. Үүний нэгэнд,

“... умар зүг урвасан тэрслүү хулгай Цэрэнтогтох, Төмөр нар Халхын Сэцэн хан аймгийн Бишрэлт жанжин бэйсийн зэрэг нэгэн ард хошууны муу самуун ард лугаа сүлбэлдэн хоршоо нийлж ноднин жил муу хулгайн самуунаас зайлан одсон зүүн, баруун тэмээчин хоёр гарын зовлонгоос зайлан одоод эгэж ирээгүй сүргийн дарга Жамба, Мэнд, Дэлгэрэнгүй, Батбаяр, Чинбат, Жигжидсүрэн, Сүх, Мижид, Ням, Жалфун, Тэтгэмж, Өнөбаяр, Дэнзэнлэд, Жамц, Цэенпил, Буян, Ядамсүрэн нарын албан амны тэмээ бүгд таван зуун арван зургаагаас гадна одоо нутагт бүхий хорин дөрвөн сүргийн тамга гаргаваас зохих олны тэмээ зургаан зуу буй нь тэрхүү зовлонгоос зайлан одсон дарга хуягуудыг хэрхэн хураан цуглуулж бас ч тэдний адгуулан сахиж бүхий сүргийн тэмээг тамга гаргаж тоонд хүрэлцүүлэх ба нутагт одоо бүхий дарга нарын албаны тэмээг хэзээ тамга гаргах явдлыг сурган зааж дагаж явуулах ажаамуй”²²

хэмээн ДИУ-аас Хүрээнд суух ерөнхийлөн хэрэг шийтгэх сайд Чень Лу-гаар уламжлуулан Цэрэнтогтохыг яллахыг шаардаж байв.

Үүнд Дотоод яамнаас: “... Дарьгангын ойж ирсэн түшмэл ардыг гурван этгээдээр нийлж хил хязгаар хуваахын наана хоёр тийш татагдалгүй түр нам гүм суулгаж Дарьгангын хил хязгаар хуваахыг хүлээлгэсүгэй хэмээн бидний яамууд нэгэнт зөвлөлдсөн”²³ гэх зэргээр тэдний шаардлагыг Дотоод, Гадаад, Сан, Цэрэг, Шүүх зэрэг олон яамууд хамтран хэлэлцэн хэрэгсээгүй байна.

1921 онд Монголчууд автономит засгийг сэргээсэнд даруйд Их шавь Магсаржав тэргүүтэй түшмэд ард Чуулалт Хаалганы сайдыг түшсэн бүгдийн тэргүүн Буяндэлгэр нартай нийлж дагаар орохоо дахин илэрхийлсэн байна. Дарьгангачууд Монгол Улсад нэгдсэний дараачаас бүгдийн тэргүүн Буяндэлгэр нар Их шавийн захиргаанд орсон ардуудыг эргүүлэн авахыг хүсэн Ардын засгийн газраа удаа дараа өргөдөл гарган Цэрэнтогтох лугаа харилцан заалдсан

²² МУУТА, ХА-4. Д-1. ХН-407. Б-8

²³ МУУТА, ХА-4. Д-1. ХН-407. Б-12

байна. Ардын засгийн газраас тэрхүү хэргийг удаа дараа нягтлан байцаагаад, "... хэдий Чуулалт Хаалганы сайдын түшиж байсан түшмэл ардын ихэнх нь Монгол Улсад нэгдсэн ч Дарьгангаас ойн гарч Их шавьд захирагдсан ардыг шууд шилжүүлэхийг төвдөлгүй тэдний дур саналыг харгалзахаар тогтоож түшмэл Раднаабазар, түшмэл Бат-Очир нарыг удаа дараа томилон байцаалгасанд 135 өрх хэвээр Цэрэнтогтохоор, 18 өрх Буяндэлгэрээр захируулахаар болсон байна"²⁴.

1924.06.06-нд өдөр болсон Засгийн газрын 17 дугаар хурлаар: "... Дарьгангын орон гарсан бүгдийн даргад олны сонгосон Цэрэнпаламыг тохоовоос болох эсэхийг тогтоомуй хэмээн ирснийг хэлэлцээд ёсоор болгон баталсны"²⁵ дараагаар Тэрбээр Их шавьд орсон нэг зуу илүү өрхийн түшмэл ард урьдах тэргүүн Буяндэлгэрийн дарлан зовоохоос бэрхшээн явсны тул одоо энэ завсар мөнхүү Буяндэлгэр бие барж айж эмээх газаргүй болсны учир тэдний биесийг өрх хөрөнгийн хамтаар уул нутагт эргүүлэн шилжүүлэхийг гуйж 284 тоот бичгээр"²⁶ Засгийн газраа өргөн барьж Цэрэнтогтохтой зарга үүсгэх болсон байна. Гэвч Засгийн газраас нэгэнт шийдсэн хэрэг тул түүний асуудлыг үл хэрэгссэн байна. Ийнхүү салж нүүсэн дарьгангачууд нийлээгүй үлдсэн байна.

Дүгнэлт

Дарьгангын удирдлагуудын хооронд үүссэн зөрчлүүдийг тодорхой хэмжээнд судлан дараах хэдэн гаргалгааг хийж байна. Үүнд,

Дарьгангын удирдлага нь угсаа залгамжладаггүй боловч бүгдийн тэргүүнийг тохоохдоо гарын дарга нарын дотроос сонгодог, гарын дарга нарыг тохоохдоо ард олныг баримтлан захирах, эрдэм чадлыг харгалздаг ч бүгдийн тэргүүний оролцоо байв. Хэдий сонгох журмаар томилогддог чөлөөтэй мэт харагдах боловч энэхүү барьцалдсан тогтолцоо нь нийгмийн удирдлага бүрэлдэх нөхцөл болж XX зууны эхэн үе гэхэд Дарьгангын удирдлагад хоёр бүлэг нэгэнт бий болсон байна. Иймээс тэдгээр түшмэд өөрөө болон нөлөөний хүнээ тушаал дэвшүүлэхийг эрэх болж бие биесийг хачилан заргалдах нь ихээхэн байжээ.

Угсаа залгамжлахгүй томилогдох тушаалын түшмэд өөрсдийн эрх ашиг, байр суурь, үзэл бодлоо хадгалан дээд тушаалд дэвшин ажиллахыг хайх болсон нь зарим талаар дотоодын удирдлагуудыг төөрөлдүүлэх, гадаадын хүчин зүйлсийн эрхэнд автахад хялбар болж байв.

Бүгдийн тэргүүн угсаа залгамжилдаггүй сонгох тушаалын алба тул тэдний хувь хүний онцлог үйл ажиллаанаас хамаарч Дарьгангын удирдлагын арга барил тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж байжээ. Ийм үед бүгдийн тэргүүн идэвхтэйгээр үйл ажиллагаа явуулж ард олны хүчийг татахыг хичээж ажилсан нь зарим талаар эерэг үр дүн өгч байв.

²⁴ МУУТА, Х-4. Д-1. ХН-35а. Х-168-168а

²⁵ МУУТА, Х-4. Д-1. ХН-57. Х-215

²⁶ МУУТА, Х-4. Д-1. ХН-66. Х-126-128

Дарьгангачууд бүрэлдэснээс түүхэн хугацаа өнгөрхөд засаг захиргааны нийтлэгийг бүрэлдүүлэн өөрсдийн тэргүүн нарыг сонгох журмаар тохоохыг уламжлал болгон хэвшүүлсэн нь ажиглагдаж байна. Жишээлбэл 1911 онд нэгдэн орсон Дарьгангыг засаг хошуу болгон өөрчилснөөс үүдэн зөрчил гарч байв. Жич тэмдэглэхэд түүхт их ой давхацсан 2011 онд дарьгангачууд Монгол Улсад нэгдэн орсон 100 жилийг ой давхар тохиож буй юм.

Abstract: In 1697, Qing emperor Kangxi settled special imperial horse herders in Dariganga, for army necessity. After suppressing the Zыnghars, camel and sheep herders were settled in Dariganga territory at the end of the XVII century. History of the establishment of herders of Dariganga is one of the real example of Qing dynasty's policy. Because, at first, Dariganga's territory was a gate land to pass through Mongolian great desert, secondly, was settled herders of Dariganga for strengthening Manchu army entering to Western or Central Mongolia and Chinese North border, thirdly, Dariganga pasture is very comfortable to grow cattle breeding and its situation was conformed perfectly with first two policies.

However named "Dariganga herder", Dariganga is consisted of Khalkha, Tsakhar, Oirat ethnic groups. Dariganga was under the Zhangjiakou (Kalgan) and had no hereditary nobility. But In the beginning of the XIX century the admitted group established. There are divided 2 under Sodnomdovdon & Buyandelger. The бэгдгйин төрхьн Sodnomdovdon, Buyandelger, Tsevegjav, Tserenpalam, Tserentogtokh and Magsarjav main roled its.

In 1911 the restoration of Mongolian independence, the Dariganga officials petitioned to join to Mongolia. After the 1915 Kyakhta trilateral treaty, Dariganga was divided into 2, some escaped to the Khalkha territory and joint to the Great shabi, or the emperor's personal estate. Others escaped to Janchkhuu. So it was named south Dariganga and north Dariganga by local animated conversation.